



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2004 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

### Г Ажлын байрны дагалдан сургалтын Г хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.2 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 97/56 дугаар тушаал, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ажлын байрны дагалдан сургах сургалттай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон Зоонозын өвчин судлалын төвүүдэд шинээр ажилд орсон "Тархвар судлагч", "Нян судлагч", "Биологич", "Лаборант", "Ариутгагч", "Дээд мэргэжилтэн"-г дагалдуулан сургах хөтөлбөрийг нэгдүгээр, Суралцагсдын төлбөрийг хоёрдугаар, суралцагчдад олгох гэрчилгээний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төв, аймаг, нийслэлийн ЗӨСТ-д шинээр ажилд орсон мэргэжилтнүүдийг хөтөлбөрийн дагуу дагалдуулах сургалтыг зохион байгуулж, дадлагажих хугацааг дуустал бүрэн суралцуулахыг Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны дарга (Д.Алтантогтох), Сургалтын менежер (П.Алтангэрэл) нарт тус тус даалгасугай.

3. Сургалтын төлбөрийг холбогдох журмын дагуу зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (З.Ууганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (Ц.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төвийн захирлын 2015 оны А/36 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ



## ДАГАЛДАН СУРГАЛТЫН НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. Дагалдан сургалтын зорилго нь Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд шинээр ажилд орсон мэргэжилтнүүдийг ажлын байранд дагалдлуулан албан тушаалтын тодорхойлолтын дагуу ажиллах ерөнхий чиг баримжаа олгох сургалт юм.
2. Тус төв болон аймаг, нийслэлийн ЗӨСТ-д шинээр ажилд орсон мэргэжилтнүүдийг ажилд орсноос хойш 1 сараас дээшгүй хугацаанд уг сургалтад заавал хамруулах.
3. Уг журамд зааснаас гадна өөр чиглэлээр богино хугацаанд ажлын байр, албан тушаалын чиглэлээр сургалтад хамруулж болно.
4. Суралцагч өөрөө бие дааж судлах боломжтой хөтөлбөрийг сургалтын цагаас хасч өөрийн хүсэлтээр нэмэлт хөтөлбөрт хамрагдах боломжтой юм.



Төвийн ерөнхий захирлын  
2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн  
169 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## БИОЛОГИЧИЙГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР

**Сургалтын зорилго:** Байгалийн голомтот, зоонозын халдваруудын байгалийн голомтыг тандан судлах, илрүүлэх, судалгаа шинжилгээ хийх аргачлал, багаж тоног төхөөрөмжийг ашиглан гардан үйлдлийн аргачлалыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

### Сургалтын зорилт:

1. Байгалийн голомт, зоонозын халдваруудын үед баримтлах халдвар хамгааллын дэглэм, биоаюулгүй ажиллагааны талаар мэдлэг, дадлыг олгох
2. Байгалийн голомт, зоонозын өвчний агуулагч, дамжуулагч амьтдыг шинжлэх, судлах арга ажиллагааны зарчим, байгалийн голомтын зүй тогтолын талаарх онолын мэдлэгийг эзэмшүүлэх
3. Зоонозын халдваруудын байгалийн голомтын тандалт судалгааны аргууд, багаж хэрэгслийг ашиглах чадварыг эзэмшүүлэх

**Зайлшгүй эзэмших мэдлэг:** Зоонозын халдваруудын байгалийн голомтын тандалт судалгааны хэлбэр, арга, аргачлал, хариу арга хэмжээний талаарх мэдлэгийг эзэмшинэ.

**Зайлшгүй эзэмших ур чадвар:** Зоонозын халдварт өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах, голомтод ажиллах чадварыг эзэмших

**Сургалтын хугацаа:** 12 өдөр /ажлын/



## БИОЛОГИЧИЙН ДАГАЛДАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хичээлийн сэдэв	Цаг	
		онол	дадлага
1	Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийг мөрдөх, хэрэгжүүлэх, хамгаалах өмсгөл өмсөж тайлах аргачлал, биоаюулгүй ажиллагаа	1	3
2	Амьтан судлал, шимэгч судлагчийн ажлын байрны үндсэн чиглэл, ажил үүргийн хуваарь	1	
3	Амьтан судлал, шимэгч судлалын лаборантын ажлын байрны үндсэн чиглэл, ажил үүргийн хуваарь	1	
4	Байгалийн голомтын хяналт шинжилгээний заавартай танилцах		24
5	Амьтан судлалын судалгааны арга зүй		6
6	Шимэгч судлалын судалгааны арга зүй		6
7	Амьтан судлал, шимэгч судлалын анхан шатны бүртгэл хөтлөх		3
8	Удирдамж гаргах, тайлан бичих		6
9	Зоонозын өвчний холбогдолтой амьтны дуудлагад үйлчлэх, бэлэн байдлыг хангах	1	5
10	Амьтан тодорхойлох, самнах, гадны шимэгч тодорхойлох		6
11	Материал дээжлэх, амьтан олзворлох		6
12	Өөрийн хүсэлтээр нэмэх		
<b>Нийт</b>		<b>4</b>	<b>65</b>
<b>Нийт : 69 цаг / ажлын 12 өдөр</b>			
<b>Шалгалт</b>			



## НЯН СУДЛАГЧИЙГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР

**Сургалтын зорилго:** Байгалийн голомт, зоонозын өвчний лабораторийн шинжилгээний стандарт ажиллагааны аргачлалууд, бичил харах, нян судлал, ийлдэс судлал, биологийн шинжилгээний аргуудыг технологийн дагуу гүйцэтгэх, биоаюулгүй ажиллагааны мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

### **Сургалтын зорилт:**

1. Байгалийн голомт, зоонозын халдваруудын үед баримтлах халдвар хамгааллын дэглэм, биоаюулгүй ажиллагааны талаарх мэдлэг, чадвар, дадлыг олгох
2. Байгалийн голомт, зоонозын халдваруудын лабораторийн шинжилгээ, оношилгоог (бичил харах, нян судлал, ийлдэс судлал, вирус судлал, молекул биологи) технологийн дагуу гардан гүйцэтгэх, мөрдөгдөх биоаюулгүй ажиллагааны мэдлэг, чадварыг эзэмшүүлэх

### **Зайлшгүй эзэмших мэдлэг:**

Зоонозын халдваруудын шинжилгээ оношилгооны технологийн арга, аргачлал, хариу арга хэмжээ, биоаюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийг эзэмшинэ.

**Зайлшгүй эзэмших ур чадвар:** Зоонозын өвчний шинжилгээ, оношилгооны технологийн аргачлал, техник ажиллагаа, гардан ажиллагаа, дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах, голомтод ажиллах чадварыг эзэмших

**Сургалтын хугацаа:** 15 өдөр /ажлын/



## НЯН СУДЛАГЧИЙГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сургалтын сэдэв	Цаг	
		Онол	Дадлага
1	Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийг мөрдөх, хэрэгжүүлэх, хамгаалах өмсгөл өмсөж тайлах аргачлал, биоаюулгүй ажиллагаа	1	3
2	Лабораторийн зохион байгуулалт, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, халдвар хамгаалал	1	3
3	Лабораторийн шинжилгээний техник ажиллагаа (Нян судлал, ийлдэс судлал)	2	10
4	Онцшилгооны лабораториудыг ажилд бэлтгэх, шилэн эдлэлийг угаах технологи, угаалгын чанарыг шалгах	1	1
5	Хүчилтөрөгч, фенол, альдегид агуулагч болон гадаргын идэвхтэй бодисууд, исэлдүүлэгч ба идэвхжүүлэгч бодисуудын зориулалт, найруулах, хадгалах технологи	1	-
6	Халдваргүйжүүлэлтэд хэрэглэдэг шүршигч багажуудыг ажиллуулах технологи, аюулгүй ажиллагаа	1	1
7	Ариутгалын физик аргууд, хуурай халуун ба даралттай уураар ариутгах технологи, дезкамер, автоклавыг ажиллуулах технологи	1	1
8	Халдваргүйжүүлэлтэд халдвартай ба сэжигтэй материалыг хүлээн авах, бүртгэх, тооцох, халдвартай хог хаягдлыг устгах дэглэм, халдваргүйжүүлэлтэд хөтлөх АШБМаягт	1	1
9	Лабораторийн шинжилгээнд хэрэглэгдэх тэжээлт орчин, будаг, урвалжийн ангилал, бэлтгэх, савлах, хэрэглэх, хадгалах, тээвэрлэх технологи арга зүй, хөтлөгдөх АШБМ	1	2
10	Лабораторийн шинжилгээний зарчим, хэлбэрүүд, үндсэн аргууд: наац, дарц бэлтгэх, будах, хатуу, шингэн тэжээлт орчинд суулгац хийх технологи арга зүй, тоног төхөөрөмж болон багаж хэрэгслийг ашиглах	1	3
11	Биологийн шинжилгээний ач холбогдол, туршлагын амьтанд халдвар хийх, туршлагын амьтан задлах, сорьц материал дээжлэх техник ажиллагаа	1	3
12	Молекул генетикийн оношилгооны зарчим, ПГУ-ын техник ажиллагаа, плазмид тодорхойлох аргууд	1	3
13	Вирус судлалын лабораторийн зохион байгуулалт, шинжилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр төрөл, вирусийн эсрэгтөрөгч илрүүлэх хурдавчилсан	1	6



	сорил, Дархан туяаралт бичил харах, фермент холбоот урвалын аргууд		
14	Халдвартай ба сэжигтэй материалыг шилжүүлэх, нянгийн амьд өсгөвөр, омгийг хадгалах тээвэрлэх ажиллагаа	-	3
15	Лабораторийн шинжилгээнд хөтлөгдөх АШБМ, тайлан, мэдээ гаргах, мөрдөх эрх зүйн актууд	-	2
16	Хачгаар дамжих халдварт өвчний (энцефалит, боррелиоз, риккетсиоз) тархвар судлал, байгалийн голомт, лабораторийн шинжилгээ оношилгоо	1	3
17	Холер өвчний тархвар судлал, урьдчилан сэргийлэлт, халдваргүйжүүлэлт, хүний өвчлөлийн голомтод ажиллах зарчим, лабораторийн оношилгооны онцлог	1	3
18	Боом өвчний эмнэлзүй, эмчилгээ, тархвар судлал, урьдчилан сэргийлэлт, халдваргүйжүүлэлт, хүний өвчлөлийн голомтод ажиллах зарчим, лабораторийн шинжилгээ, оношилгоо	1	6
19	Тарваган тахлын эмнэлзүй, эмчилгээ, тархвар судлал, халдваргүйжүүлэлт, урьдчилан сэргийлэлт, хүний өвчлөлийн голомтод авах арга хэмжээ, лабораторийн шинжилгээ, оношилгоо	1	6
20	Бруцеллиоз өвчний тархвар судлал, эмнэлзүй эмчилгээ, лабораторийн оношилгоо	1	-
21	Галзуу, шүлхий, хачигт энцефалит, баруун Нилийн халдвар, шувууны томуу өвчний тархвар судлал, эмнэлзүй, эмчилгээ, халдваргүйжүүлэлт, лабораторийн шинжилгээний зарчим	1	3
22	Эгэл биетнээр үүсгэгддэг халдваруудын тархвар судлал, эмнэлзүй, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, лабораторийн оношилгоо	1	2
23	Анзаарагддаггүй нянгийн гаралтай өвчнүүдийн тархвар судлал, байгалийн голомт, лабораторийн шинжилгээ оношилгоо	1	3
24	Өөрийн хүсэлтээр нэмэх сэдэв		
		<b>22</b>	<b>68</b>
<b>Нийт : 90 цаг / ажлын 15 өдөр</b>			



## ТАРХВАР СУДЛАГЧИЙГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР

**Сургалтын зорилго:** Байгалийн голомт, зоонозын халдваруудын тархвар судлал, урьдчилан сэргийлэх ажлын мэдлэг чадварыг эзэмшихэд чиглэгдэнэ.

### **Сургалтын зорилт:**

1. Байгалийн голомт, зоонозын халдваруудын үед баримтлах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны талаарх мэдлэг, чадвар дадлыг олгох
2. Байгалийн голомт, зоонозын халдваруудын үед баримтлах ариутгал, халдваргүйжүүлэлтийн технологийг эзэмших
3. Тархвар судлал, тандалт судалгааны аргуудад суралцах
4. Байгалийн голомт, зоонозын халдваруудын хүний өвчлөлийн тохиолдол, дэгдэлтийн үед голомтод ажиллах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг зохион байгуулах чадварыг эзэмших

**Зайлшгүй эзэмших мэдлэг:** Байгалийн голомт, зоонозын өвчний тархвар судлал, тандалт судалгааны аргууд, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний талаарх мэдлэгийг эзэмшинэ.

**Зайлшгүй эзэмших ур чадвар:** Зоонозын өвчний тархвар судлалын аргуудаас сонголт хийх, хэрэглэх, халдварт өвчний статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх, хүний өвчлөлийн тохиолдол, дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах голомтод ажиллах чадварыг эзэмшинэ.

**Сургалтын хугацаа:** 15 өдөр /ажлын/



ТАРХВАР СУДЛАГЧИЙГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР

№	Сургалтын сэдэв	Цаг	
		онол	дадлага
1	Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийг мөрдөх, хэрэгжүүлэх, хамгаалах өмсгөл өмсөж, тайлах аргачлал, биоаюулгүй ажиллагаа	1	2
2	Тархвар судалгааны үндсэн аргууд, тархвар судлалын ажлыг төлөвлөх, тархвар судлалын шинжилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлан бичих	3	6
3	Боом, Бэтэг, Хуурамч ям, Татран, Лептоспироз, Орф вирус, Лейшманиоз, Гельминт халдварт өвчний эмнэлзүй, эмчилгээ, тархвар судлал, халдваргүйжүүлэлт, урьдчилан сэргийлэлт, хүний өвчлөлийн голомтод авах арга хэмжээ, лабораторийн шинжилгээ, оношилгоо, халдваргүйжүүлэлт	2	4
4	Тарваган тахал, хулгана тахал, япон энцефалит, эризелепойд, пастереллөз, листериоз, хуурмаг сүрьеэ, иерсиниозын халдварт өвчний эмнэлзүй, эмчилгээ, тархвар судлал, халдваргүйжүүлэлт, урьдчилан сэргийлэлт, хүний өвчлөлийн голомтод авах арга хэмжээ, лабораторийн шинжилгээ, оношилгоо, халдваргүйжүүлэлт	2	4
5	Галзуу, денге, бруцеллөз, шар чичрэг (Zika Chinkungunya), Марбургийн цусархаг чичрэг, хендра вируст халдварт өвчний эмнэлзүй, эмчилгээ, тархвар судлал, урьдчилан сэргийлэлт, лабораторийн шинжилгээ, оношилгоо	2	4
6	Шувууны томуу, АЦХаХ, Баруун Нилийн чичрэг, Эбола, Ласса, Непак вируст халдварт өвчний эмнэлзүй, эмчилгээ, тархвар судлал, урьдчилан сэргийлэлт, лабораторийн шинжилгээ, оношилгоо	2	4
7	Хачигт энцефалит, боррелиоз, риккетсиоз, эрлихиоз, анаплазмоз, MERS-CoV, Крым-Конгийн цусархаг хам шинж халдварт өвчний эмнэлзүй, эмчилгээ, тархвар судлал, урьдчилан сэргийлэлт, лабораторийн шинжилгээ, оношилгоо	2	4
8	Холер, бабезиоз, хумхаа, токсоплазмоз, кампилобактерт энтерит, криптоспоридоз, шүлхий өвчний тархвар судлал, урьдчилан сэргийлэлт, халдваргүйжүүлэлт, хүний өвчлөлийн голомтод ажиллах зарчим, оношилгооны онцлог	2	4
9	Дархлаажуулалтыг төлөвлөх, зохион байгуулах арга, вакцины нэр төрөл, хадгалалт, зарцуулалт, хөтлөгдөх маягууд	1	5
10	Хүн амын дунд болон эмнэлгийн ажилтнуудад эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг зохион байгуулах арга, санамж, зурагт хуудас боловсруулахад анхаарах асуудал	1	2



11	Урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах ажиллагаа, урьдчилан сэргийлэх ажлын үзүүлэлтүүдийг нэгтгэх, тайлан мэдээ гаргах арга	1	2
12	Халдварт өвчний голомтод авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, үндсэн чиглэл	1	2
13	Зоонозын халдварын хүний өвчлөлийн үед тандалт, оношилгоо, эмчилгээний стандартыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг дүгнэх	1	2
14	Халдваргүйжүүлэлтэд халдвартай ба сэжигтэй материалыг хүлээн авах, бүртгэх, тооцох, халдвартай хог хаягдлыг устгах дэглэм, халдваргүйжүүлэлтэд хөтлөх АШБМаягт	-	2
15	Халдваргүйжүүлэлтэд хэрэглэдэг шүршигч багажуудыг ажиллуулах технологи, аюулгүй ажиллагаа	-	2
16	Ариутгалын физик аргууд, хуурай халуун ба даралттай уураар ариутгах технологи, дезкамер, автоклавыг ажиллуулах технологи	-	2
17	Дуудлагын бэлэн байдлыг хангах	-	2
18	Хүний өвчлөлийн тайлантай танилцах	-	2
19	Эрсдэлийн үеийн харилцаа холбоо	-	2
20	Шуурхай удирдлагын нэгжтэй танилцах, дадлага	-	1
21	Статистик мэдээ, мэдээллийн тогтолцоо	-	1
22	Лабораторийн үйл ажиллагаа, шинжилгээний төрлүүд,	-	4
23	Био үйлдвэрлэлтэй танилцах	1	2
24	Эпизоотологийн тухай ойлголт	1	2
25	Өөрийн хүсэлтээр нэмэх сэдэв		
<b>Нийт</b>		23	67
<b>Нийт : 90 цаг / ажлын 15 өдөр</b>			
<b>Шалгалт</b>			



## АРИУТГАГЧИЙГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР

**Сургалтын зорилго:** Зоонозын өвчний эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний хүрээнд ариутгал халдваргүйжүүлэлтийн арга технологи, биоаюулгүй ажиллагааны мэдлэг, чадварыг эзэмшихэд чиглэгдэнэ.

### Сургалтын зорилт:

1. Зоонозын өвчний үед баримтлах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны мэдлэг, чадвар дадлыг олгох
2. Лабораторийн зохион байгуулалтын талаарх мэдлэгийг эзэмшүүлэх
3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлт хийх технологи, түүнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хэрэглэгдэх бодисуудын талаарх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх
4. Зоонозын өвчний чиглэлээр баримталж буй стандарт, тушаал, заавар, журмын хэрэгжилт

**Зайлшгүй эзэмших мэдлэг:** Байгалийн голомтот зоонозын өвчнүүдийн үүсгэгч, тэдгээрийн тархалт, хүний өвчлөлийн голомтод халдваргүйжүүлэлт хийх, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэл хийх, байгалийн голомтот зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаарх мэдлэгийг эзэмшинэ.

**Зайлшгүй эзэмших ур чадвар:** Халдварт өвчний үүсгэгч бичил биетэн, тэдгээрийн халдварын эх уурхай, тархах механизм, гадаад орчин дахь амьдрах чадвар, тэдгээрт физик, хими, биологийн аргаар үйлчилж халдваргүйжүүлэлт, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэл хийх ур чадварт суралцана.

**Сургалтын хугацаа:** 12 өдөр /ажлын/



**АРИУТГАГЧИЙГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Сургалтын сэдэв	Цаг	
		онол	дадлага
1	Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийг мөрдөх, хэрэгжүүлэх, хамгаалах өмсгөл өмсөж, тайлах аргачлал, биоаюулгүй ажиллгааны ерөнхий зарчим	1	5
2	Халдваргүйжүүлэлтийн ангилал, ариутгагчийн ажил үүргийн онцлог, химийн халдваргүйжүүлэлтэд ашигладаг бодисуудын ангилал, бичил биетэнд үйлчлэх механизм	2	-
3	Халдваргүйжүүлэлтэд мөрдөх эрх зүйн актууд, хөтлөх АШБМ-ууд	2	3
4	Халдварт өвчний голомтын төрөл, дуудлагын бэлэн байдлыг хангах; дуудлагад үйлчлэх	2	4
5	Оношилгооны лабораториудыг ажилд бэлтгэх, шилэн эдлэлийг угаах технологи, угаалгын чанарыг шалгах	1	5
6	Зөөлөн эдлэлийг ариутгалд бэлдэх - Хөвөн марлин бөглөө хийх - Хөвөн марлин маск хийх, ариутгах	-	5
7	Лабораторид хэрэглэгдэх зөөлөн болон шилэн эдлэлийг автоклавт ариутгах	-	4
8	Лабораторид хэрэглэх шилэн эдлэлийг ариутгах	-	4
9	Ариутгал, халдваргүйжүүлэлтийн чанар шалгах, ариутгасан материалыг хадгалах	-	2
10	Зоонозын халдварт өвчний үед өргөн хэрэглэгддэг халдваргүйжүүлэлтийн бодисуудын найруулах, хэрэглэх арга, аюулгүй ажиллагааны зааварчилгаа	1	3
11	Халдваргүйжүүлэлтэд хэрэглэдэг багажуудыг ажиллуулах технологи, аюулгүй ажиллагаа	1	3
12	Ариутгалын физик аргууд, хуурай халуун ба даралттай уураар ариутгах технологи, автоклавыг ажиллуулах технологи	1	2
13	Халдвартай ба сэжигтэй материалыг хүлээн авах, бүртгэх, тооцох, халдвартай хог хаягдлыг устгах дэглэм, халдваргүйжүүлэлтэд хөтлөх АШБМаягт	1	4
14	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент	1	3
15	Нянгийн гаралтай зоонозын халдварт өвчний байгалийн голомт ба хүний өвчлөл, халдваргүйжүүлэлтийн онцлог	2	4
16	Вирусээр үүсгэгддэг халдварт өвчний байгалийн голомт ба хүний өвчлөл, халдваргүйжүүлэлтийн онцлог	2	4
17	Өөрийн хүсэлтээр нэмэх сэдэв		
<b>Нийт</b>		17	55
<b>Нийт : 72 цаг / 12 өдөр</b>			
<b>Шалгалт</b>			



## НЯН СУДЛАЛЫН ЛАБОРАНТЫГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР

**Сургалтын зорилго:** Зоонозын өвчний лабораторийн шинжилгээний стандарт ажиллагааны аргачлалууд, бичил харах, нян судлал, ийлдэс судлал, биологийн шинжилгээний аргуудыг технологийн дагуу техник ажиллагааг гүйцэтгэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

### **Сургалтын зорилт:**

1. Зоонозын өвчний үүсгэгчийн халдвартай ба сэжигтэй материалтай ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны үед баримтлах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны мэдлэг, чадвар, дадлыг олгох

2. Лабораторийн зохион байгуулалтын талаарх мэдлэгийг эзэмшүүлэх

3. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн технологи, түүнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хэрэглэгдэх бодисуудын талаарх мэдлэг чадварыг эзэмшүүлэх

4. Байгалийн голомт, зоонозын өвчний лабораторийн шинжилгээний (бичил харах, нян судлал, ийлдэс судлал, биологи) арга, технологи, мөрдөх аюулгүй ажиллагааны мэдлэг чадварыг эзэмшүүлэх

5. Зоонозын өвчний чиглэлээр баримталж буй стандарт, тушаал, заавар, журмын хэрэгжилт

**Зайлшгүй эзэмших мэдлэг:** Байгалийн голомтот зоонозын өвчнүүдийн үүсгэгч, тэдгээрийг оношлох лабораторийн шинжилгээний арга, технологи, техникийн талаарх мэдлэгийг эзэмшинэ.

**Зайлшгүй эзэмших ур чадвар:** Байгалийн голомт, зоонозын өвчнийг шинжлэх арга, техник ажиллагаа, нянгийн амьд өсгөвөр, омгийг хадгалах тээвэрлэх, хүлээн авах, шилжүүлэх технологи, биохамгаалал, биоаюулгүй ажиллагааны мэдлэг чадварт суралцсан байна.

**Сургалтын хугацаа:** 15 өдөр /ажлын/



## НЯН СУДЛАЛЫН ЛАБОРАНТЫГ ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР

№	Сургалтын сэдэв	Цаг	
		онол	дадлага
1	Лабораторийн биоаюулгүй ажиллагааны ерөнхий зарчим, лабораторийн зохион байгуулалт, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, халдвар хамгаалал, хамгаалах өмсгөл өмсөж, тайлах аргачлал	1	5
2	Оношилгооны лабораториудад ажлын өмнөх цэвэрлэгээ, үйлчилгээ хийх, шилэн эдлэлийн нэр төрөл, тэдгээрийг угаах, угаалгын чанарыг шалгах	-	3
3	Лабораторийн шинжилгээнд хэрэглэдэг тэжээлт орчин, будаг урвалжийн ангилал, үйлдвэрлэлийн зарчим, бэлтгэх, савлах, хадгалах, тээвэрлэх ажиллагаа, захиалга хийх	-	3
4	Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ангилал, хэрэглээ, физик аргуудын бичил биетэнд үйлчлэх механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл, аюулгүй ажиллагаа, чанар шалгах арга	1	2
5	Лабораторийн зохион байгуулалт, шинжилгээний үндсэн аргууд, шинжлэгдэхүүний нэр төрөл, лаборантын ажил үүргийн онцлог	1	3
6	Лабораторийн шинжилгээний техник ажиллагаа (нян судлал, ийлдэс судлал), баримтлах аюулгүй ажиллагаа, халдвар хамгааллын дэглэм	4	21
7	Амь сорьцын лабораторийн зохион байгуулалт, биологийн шинжилгээний техник, баримтлах аюулгүй ажиллагаа, хөтлөгдөх АШБТ	1	5
8	Молекул генетикийн оношилгооны зарчим, зохион байгуулалт, шинжилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр төрөл, зориулалт хэрэглээ	1	6
9	Вирус судлалын лабораторийн зохион байгуулалт, шинжилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр төрөл, зориулалт хэрэглээ	1	1
10	Халдвартай ба сэжигтэй материалыг шилжүүлэхэд бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх горим	1	2
11	Тарваган тахал өвчний лабораторийн оношилгооны зарчим	1	3
12	Боом өвчний лабораторийн оношилгооны зарчим	1	3
13	Холер өвчний лабораторийн оношилгооны зарчим	1	3
14	Хачигт боррелиоз, риккетсиоз өвчний лабораторийн оношилгооны зарчим	1	3
15	Вирусээр үүсгэгддэг халдваруудын лабораторийн оношилгооны зарчим	1	5



16	Анзаарагддаггүй нянгийн гаралтай халдварт өвчний тархвар судлал, байгалийн голомт, лабораторийн оношилгооны техник арга зүй	1	5
17	Өөрийн хүсэлтээр нэмэх сэдэв		
<b>Нийт</b>		<b>17</b>	<b>73</b>
<b>Нийт : 90 цаг / 15 өдөр</b>			



## БУСАД ДЭЭД МЭРГЭЖИЛТЭН ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР

**Сургалтын зорилго:** Байгалийн голомт, зоонозын халдваруудын талаар мэдээлэл, холбогдох хууль эрх зүйн мэдээллүүдээр хангаж тухайн ажлын байрны үйл ажиллагаанд чиглэсэн мэдлэг эзэмшихэд чиглэгдэнэ.

### **Сургалтын зорилт:**

1. Байгалийн голомт, зоонозын халдваруудын үед баримтлах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны талаарх мэдлэг олгох
2. Зоонозын халдваруудын талаарх мэдээлэл, аюулын зэрэглэл, авах арга хэмжээний талаарх ойлголтыг өгөх.
3. Албан тушаал ажлын байрны дагуу холбогдох хууль эрх зүйн мэдээллээр хангах.
4. Чиглэлийн мэргэжилтэн дагалдуулан чиглүүлж дадлагажуулна.

**Сургалтын хугацаа:** 10 өдөр /ажлын/




**БУСАД ДЭЭД МЭРГЭЖИЛТЭН ДАГАЛДУУЛАН СУРГАХ ХӨТӨЛБӨР**

№	Сургалтын сэдэв	Цаг	
		онол	дадлага
1	Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийг мөрдөх, хэрэгжүүлэх, хамгаалах өмсгөл өмсөж, тайлах аргачлал, биоаюулгүй ажиллагааны ерөнхий зарчим	3	3
2	Байгалийн голомт, төрөл, Монгол орны голомтууд	3	
3	Зоонозын шалтгаант халдваруудын талаарх ойлголт, тэдгээрийн аюулын зэрэглэл	3	
4	Хууль эрх зүйн мэдээлэл	3	
5	Холбогдох чиглэлийн мэргэжилтэн дагалдан суралцаж дадлагажих	1	30
6	Өөрийн хүсэлтээр нэмэх сэдэв		
<b>Нийт</b>		<b>13</b>	<b>33</b>
<b>Нийт : 56 цаг / 10 өдөр</b>			



Төвийн ерөнхий захирлын  
2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн  
1169 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧИН”-ИЙ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ  
ДАГАЛДУУЛАН СУРГАХ СУРГАЛТЫН ТӨЛБӨР

№	Сургалтын төрөл	Нэг суралцагчийн сургалтын төлбөрийн хэмжээ /төгрөг/
1	Нян судлагчийг дагалдуулан сургах сургалт	95 000
2	Тархвар судлагчийг дагалдуулан сургах сургалт	95 000
3	Биологичийг дагалдуулан сургах сургалт	70 000
4	Лаборантыг дагалдуулан сургах сургалт	90 000
5	Ариутгагчийг дагалдуулан сургах сургалт	70 000



Төвийн ерөнхий захирлын  
2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн  
А/69 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



## ДАГАЛДАН СУРГАЛТАД ХАМРАГДСАН МЭРГЭЖИЛТЭНД ОЛГОХ ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Дагалдан сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдэд олгох гэрчилгээний загвар нь:

1. Брендбүүкээр батлагдсан загварыг мөрдлөг болгоно.
2. Гэрчилгээний хуудас 105 x 148.5 /A5/ хэмжээтэй байна.
3. Гэрчилгээний гол хэсэгт төвийн бэлгэдэл байршуулж, түүний доор “Дагалдан сургалтын гэрчилгээ” гэж бичсэн байна.
4. Гэрчилгээний хуудсанд дэлгэрэнгүй овог, нэр, сургалт эрхлэх байгууллагын нэр, сургалтын нэр, сургалтын огноо, албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
5. Гэрчилгээний доод хэсэгт олгосон огноо, газрын нэрийг бичнэ.  
/Загварыг хавсаргав/

Төвийн  
бэлгэдэл

### ДАГАЛДАН СУРГАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

..... ОВОГТОЙ ..... НЬ  
Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс  
зохион байгуулсан ..... дагалдан сургалтад  
..... хоногийн хугацаанд хамрагдсан тул гэрчилгээ  
олгов.

Ерөнхий захирал .....  
/тамга, гарын үсэг/

Олгосон он, сар  
ЗӨСҮТ